



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Шударга ёс, хөгжил дэвшилд

Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг

ХЭН

- Төрийн улс төрийн, захиргааны, тусгай албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан;
- Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан болон ерөнхий нягтлан бодогч, ахлах нягтлан бодогч;
- Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах болон компанийн эрх бүхий албан тушаалтан;
- Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн дарга, гишүүн, ерөнхий захирал;
- Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авч төрийн тодорхой чиг үүргийг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтан;
- Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвшигч;
- Бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгч;
- Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 4.1.7-д заасан Ирээдүйн өв сан корпорацийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын зөвлөлийн гишүүн;
- Эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад заасан албан тушаалтан.

ХЭЗЭЭ

- Тухайн албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон өдрөөс хойш **(30 хоногийн дотор)**
- Хөрөнгө, орлогод их хэмжээний өөрчлөлт орсноос хойш **(30 хоногийн дотор)**
- Шинэчлэн гаргах **(жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор)**

ХЭРХЭН



МЭДҮҮЛЭХ ВЭ?

1. **meduuleg.iaac.mn** цахим системд нэвтрэх;
2. Мэдүүлгээ үнэн зөв мэдүүлэх;
3. Мэдүүлгийг баталгаажуулах;
4. Баталгааны маягтад гарын үсгээ зурж эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх.

